



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 016/11

Алтай хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай” 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны “Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай” 211 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ГААОНӨГ/202201045 дугаар бүхий Тайшир сумын Агропаркруу цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээ татах ажлыг хүлээн авч байнгын ашиглалтад оруулах үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Б.Бямбадорж (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн Ерөнхий архитектор)

Гишүүдэд: 3.Жаргалтуяа (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)
Р.Пүрэвдорж (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)
П.Ундрах (Тайшир сумын Засаг даргын Тамгын газрын дарга)
Ц.Амарсанаа (Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч)


2.

П.Мөнхбаатар ("Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн шуурхай үйлчилгээний монтёр ахлагч)

Нарийн бичгийн дарга: Ц.Энхмэнд ("Хуруу цахир" ХХК-ийн захирал)
(гүйцэтгэгч)

2.Барилга байгууламжийн ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3.Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг бүртгэж, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, байгууламжийн урсгал зардлыг төсөвт тусгаж, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Тайшир сумын Засаг дарга (Г.Болормаа)-д тус тус даалгасугай.

ОРЛОГЧ  Г.ЧИНБАТ